



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/241

Улаанбаатар хот

Аргачилсан заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14, 23.2.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах аргачилсан заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах аргачилсан заавар”-ыг бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, мониторингийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, сумын Газрын даамал нарт тус тус үүрэг болгосугай.
3. “Бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах аргачилсан заавар”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Газрын мониторингийн хэлтэс (Б.Дөл)-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1325011112



## **БЭЛЧЭЭРИЙН ФОТО МОНИТОРИНГИЙН ЦЭГИЙН ТӨЛӨӨЛӨХ ТАЛБАЙГ ЗУРАГЛАХ АРГАЧИЛСАН ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү аргачилсан зааврыг аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, сумын Газрын даамлууд бэлчээрийн фото мониторингийн цэгийг (цаашид “мониторингийн цэг” гэх) шинээр байгуулах, түүний төлөөлөх талбайг зураглах болон шинэчлэхэд ашиглана.
- 1.2. Байгалийн болон мал аж ахуй, хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр бэлчээрийн чанар, бүтээмж өөрчлөгдөж байгааг хянах, урьдчилан сэргийлэх, зохистой ашиглалтыг төлөвлөх, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашлаад мэдээллийн сан бүрдүүлж, олон талт мэдээллээр хангахад чиглэгдэнэ.
- 1.3. Бэлчээрийн фото мониторингийн цэгийг төлөөлөх талбай (цаашид “төлөөлөх талбай” гэх)-г нарийвчлан зураглаж, Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загваруудтай холбож, газрын мониторингийн цахим системд оруулна.
- 1.4. Мониторингийн цэг бүрт хамаарах төлөөлөх талбайг нарийвчлан зурагласнаар тухайн сум, дүүрэг, аймаг, нийслэлийн түвшинд бэлчээрийн төлөв байдлыг доройтлын зэрэглэлээр бодитой, тоон үзүүлэлттэй илэрхийлэн гаргах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлнэ.
- 1.5. Бэлчээрийн даацыг ургац (кг/га), бэлчээрийн талбай (га), бэлчээрлэх хугацаа (хоног) гэсэн 3 үндсэн үзүүлэлтээр тооцоолсноор бэлчээрийн даацыг илүү нарийвчлалтай үнэлэх, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх, ашиглалтын зохистой хэмжээг гаргахад төлөөлөх талбайн хэмжээ нь суурь мэдээлэл болно.

### **Хоёр. Бэлчээрийн фото мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайг зураглахад баримтлах зарчим**

- 1.1. Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” солбицлын тогтолцоонд үндэслэн газар зүйн мэдээллийн систем, хиймэл дагуулын мэдээ боловсруулах программ хангамж, холбогдох суурь мэдээллүүдийг ашиглана.
- 1.2. Төлөөлөх талбайг зураглахдаа засаг захиргааны хил, хөрсний 1:100000 масштабтай байр зүйн зураг, ургамлын 1:100000 масштабтай байр зүйн зураг, өндрийн тоон зураг, экосистемийн зураг, геоморфологийн зураг, газрын нэгдмэл сан, хиймэл дагуулын зургуудыг суурь болгож ашиглана.




## Гурав. Бэлчээрийн фото мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайг зураглах

3.1.Төлөөлөх талбайн хэмжээг нарийвчлан зураглах ажил дараах үе шатуудтай байх бөгөөд хийж гүйцэтгэх ажлын дараалал нь схемд 1-д заасны дагуу явагдана. Үүнд:

- Бэлтгэл ажил;
- Материал боловсруулалт;
- Газрын мониторингийн системд бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг оруулах.

Схем 1. Бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайг зураглах технологийн дараалал



### 3.1.1 Бэлтгэл ажил

Зураглал хийхэд шаардлага хангасан үзүүлэлт, хүчин чадалтай дараах программ хангамж болон техник хангамжийг бэлтгэнэ. Үүнд:

- Газар зүйн мэдээллийн системийн программ хангамж;
- Хиймэл дагуулын зураг боловсруулах программ хангамж;
- Хүчин чадал сайтай компьютер.

Төлөөлөх талбайн хэмжээг нарийвчлан зураглахтай холбогдсон суурь судалгааны дараах өгөгдөл материалуудыг цуглуулна. Үүнд:

- Мониторингийн цэгүүдийн байршлын тоон мэдээлэл (.shp);
- Газрын нэгдмэл сангийн тооллого, тайлан тоон мэдээлэл (.shp);
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг тоон мэдээлэл (.shp);
- Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө (хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар, өвөлжөө хаваржааны доорх газар гэх мэт бэлчээрээс өөр зориулалтаар ашиглуулах, эзэмшүүлэх газрын төлөвлөгөө) тоон мэдээлэл (.shp);

- Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын бүсүүд (одоогоор бэлчээрээр ашиглаж байгаа газрыг тодруулах) тоон мэдээлэл (.shp);
- Хөрсний 1:100 000 масштабтай зургийн тоон мэдээлэл (.shp);
- Ургамлын 1:100 000 масштабтай зургийн тоон мэдээлэл (.shp);
- Өндрийн тоон загвар 12.5 м нарийвчлалтай зургийн тоон мэдээлэл (raster);
- Цөлжилтийн зургийн тоон мэдээлэл (raster);
- Экосистемийн зургийн тоон мэдээлэл (.shp);
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, гол, нуурын эрэг орчмын татмын байгалийн хилийн зураг, тоон (.shp) мэдээлэл.

Дээрх суурь мэдээллүүдийг ITRF2020 солбицлын тогтолцоо, UTM тусгаг (N45, N46, N47, N48, N49, N50) бүсэд давхцуулан тоон хэлбэрээр бэлтгэнэ.

Суурь мэдээллүүдийг давхцуулан зураглахдаа газар зүйн мэдээллийн систем ArcMap эсвэл QGIS программ ашиглан Засгийн газрын тогтоолоор батлагдсан солбицлын нэгдсэн тогтолцоонд хөрвүүлсэн байна.


### 3.1.2 Материал боловсруулалт

Газрын нэгдмэл сангийн хамгийн сүүлийн мэдээг (vector data) ашиглах ба бэлчээрийн зориулалтаар ашиглагдаагүй газруудыг тогтоож, зураглал хийж, бэлчээрээс хасаж тооцно. Зураглахдаа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2023 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам”-ыг ашиглана.

Тухайн сумын одоо ашиглаж буй бэлчээрийн төлөөлөх талбайн хил заагийг зураглахдаа газрын нэгдмэл сангийн дараах ангиллын дагуу бодитоор тодорхойлно. Үүнд:

- Ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн газрын байршил, хэмжээг тодорхойлохдоо газрын нэгдмэл сангийн тоон зураг ашиглах ба шаардлагатай тохиолдолд хиймэл дагуулын зурагтай тулгалт хийж бэлчээрийн газраас хасаж тооцно.
- Зам, шугам сүлжээний газрын байршил, хэмжээг тодорхойлохдоо газрын нэгдмэл сангийн тоон зураг ашиглан тогтоож бэлчээрийн газраас хасаж тооцно.
- Усны сан бүхий газрыг зураглаж, хэмжээг тодорхойлохдоо газрын нэгдмэл сангийн тоон зураг, хиймэл дагуулын зураг ашиглах, мөн 1:100 000 масштабтай байр зүйн зургийн тодотголд тэмдэглэгдсэн гол, мөрөн, нуур, цөөрөм, тойрмын эргээр зураглаж бэлчээрийн газраас хасаж тооцно.
- Хот тосгон, бусад суурины газрын хилийн зааг /тэг гортиг/-ийг хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан зураглаж бэлчээрийн газраас хасаж тооцно. *(Амралт, аялал жуулчлалын газарт хүүхдийн зуслан, амралтын газар, аялал жуулчлалын бааз, рашаан сувиллын газрын хамгаалалтын бүсийг бэлчээрт тооцно.)*
- Сумын одоо ашиглаж байгаа бэлчээрийн талбайг зураглахдаа бэлчээрийн зориулалтаар ашиглагдаагүй газрыг газрын нэгдмэл сангийн тоон зурагтай давхцуулан зураглана.





Зураг 1. Фото мониторингийн цэгийг газрын нэгдмэл сангийн зурагтай давхцуулсан байдал


- Тухайн сумын газрын нэгдмэл сангийн зураг дээр мониторингийн цэгийг буулгана (Зураг 1).
- Мониторингийн цэг нь бэлчээрээс бусад ангиллын газраас 100 метрээс ойр байх тохиолдолд уг мониторингийн цэгийн байршлыг бага зэрэг өөрчилнө.
- Хөдөө аж ахуйн газраас бэлчээрийг тооцохдоо газрын нэгдмэл сангийн тоон зураг ашиглан бэлчээр, хадлан, атаршсан газраас бусад ангиллын газрыг одоо ашиглаж буй бэлчээрээс хасаж тооцно. Бусад газарт усалгаатай тариалан, усалгаагүй тариалан, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар, ашиглахад тохиромжгүй газар (элсэн манхан, элсэрхэг газар, хад асга, шал сайр, ургамлын бүрхэвчгүй халцгай газар) орно.
- Уурхайн газрын эзлэх талбайг тооцохдоо ашиглалтын лицензээр олгогдсон талбайтай уялдуулан ашиглалт, олборлолт явуулж буй (газрын нэгдмэл сангийн ангиллын код 2601) газрыг бэлчээрээс хасаж тооцно.
- Улсын тусгай хэрэгцээний газарт хамаарах бэлчээрийн газрыг тооцохдоо аймаг дундын отрын бэлчээр (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6601), тусгай хамгаалалттай газрын дэглэм, горимоор уламжлалт мал аж ахуйн зориулалтаар бэлчээрт ашиглагдаж буй газраас бусад газрыг одоо ашиглаж буй бэлчээрээс хасаж тооцно.  
Бусад ангиллын газраас бэлчээрт ашиглагдаж буй дараах ангиллыг бэлчээрт ашиглагдаж буй газарт хамруулна. Үүнд:
- Заган ойтой (4102) болон ой тэлэн ургах боломжийг хангахуйц газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 4104, 4108);

- Атаршсан газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 1501, 1502);
- Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимоор уламжлалт мал аж ахуйн зориулалтаар бэлчээрт ашиглахаар зөвшөөрсөн газрыг тогтоож, одоо ашиглаж байгаа бэлчээрт хамруулан тооцно.
- Агаарын шугам, шилэн кабел, салхин сэнсний доорх газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 3302, 3401, 3410, 3411);
- Хилийн зурвас газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6201). Хилийн зурвас газраас бэлчээрт тооцох газрын хил заагийг зураглахдаа сумын Газрын даамал, багийн Засаг дарга нар хамтран зураглана;
- Хилийн боомтын бүс (газрын нэгдмэл сангийн ангиллын код 7201);
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс (газрын нэгдмэл сангийн ангиллын код 5501);
- Дархан цаазат газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6101);
- Байгалийн цогцолборт газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6102);
- Байгалийн нөөцийн газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6103);
- Дурсгалт газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6104);
- Нөөц газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 2603);
- Газрын тос, нүүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (газрын нэгдмэл сангийн ангиллын код 2306);
- Нефть, хийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, агуулах (газрын нэгдмэл сангийн ангиллын код 2315);
- Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6301);
- ШУ, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг уурын талбай (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6501);
- Аймаг дундын отрын бэлчээр (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6601);
- Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6701);
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтай талбай, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай (газрын нэгдмэл сангийн ангиллын код 6801);
- Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 7301)
- Хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар (газрын нэгдмэл сангийн ангиллын код 7501);

Сумын хэмжээнд бэлчээрт ашиглаж байгаа талбайг нарийвчлан тодорхойлсноор тухайн сумын бэлчээрийн фото мониторингийн судалгаагаар хийгддэг сумын бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн даацыг нарийвчлал өндөртэй тооцоолно.


Тухайн сумын газрын нэгдмэл сангийн улирлын бэлчээрийн (газрын нэгдмэл сангийн ангиллын код 1101, 1102) хил зааг дээр фото мониторингийн цэгийг буулгана. Хэрвээ аль нэг улирлын бэлчээр дээр цэг байхгүй тохиолдолд шинээр мониторингийн цэгийг байгуулах шаардлагатай.






Зураг 2. Ашиглаж байгаа бэлчээр

- Тухайн сумын одоо ашиглаж байгаа бэлчээрийн талбай дээр фото мониторингийн цэгийг буулгана (Зураг 2).



Зураг 3. Өндрийн тоон загвар, 12.5 м нарийвчлалтай


- Мониторингийн цэгийг (12.5 м нарийвчлалтай) өндрийн тоон загвар дээр буулгаж цэгүүд геоморфологийн хувьд ямар байршил дээр байгааг тодорхойлно (Зураг 3).



Зураг 4. Экосистемийн зураг


- Мониторингийн цэгийг экосистемийн зураг дээр (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын боловсруулсан) буулгана. (Зураг 4)
- Хэрвээ мониторингийн цэг экосистемийн аль нэг үзүүлэлт дээр давхцахгүй бол фото мониторингийн цэгийг нэмэх шаардлагатай гэж үзнэ.
- Мониторингийн цэг нь тухайн сумын хөрсний хэв шинж тус бүрд давхцаж байх шаардлагатай. Хэрвээ хөрсний аль нэг хэв шинжид цэг байхгүй бол талбайн хэмжээг хуваах эсхүл нэгтгэн зураглана.
- Хөрсний нэг хэв шинжид хоёр болон түнээс дээш бэлчээрийн фото мониторингийн цэг байрлаж байвал дараах зарчмаар зураглана. Үүнд:
  - Нэн түрүүнд байгалийн хил зааг буюу газрын гадаргын хэв шинж, төмөр зам, авто зам, шугам сүлжээ зэргийг харгалзах.
  - Байгалийн хил заагийг харгалзан зураглах боломжгүй бол үүсмэл хил зааг буюу тусгай хамгаалалттай газрын хил, багийн хил, бэлчээр ашиглагчдын хил зэргийг харгалзаж, зураглах хэрэгтэй.





Зураг 5. Хөрсний 1:100 000 масштабтай зураг

- Хөрсний 1:100 000 масштабтай тоон зургийг эх материал болгон ашиглах ба мониторингийн цэгийг хөрсний зураг дээр буулгаж, хөрсний атрибут мэдээллээс "soil\_name" буюу хөрсний нэрээр ангилна. (Зураг 5)



Зураг 6. Фото мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайн зураг


- Мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайг зураглаад (Зураг 6) дараах хүснэгтийн дагуу атрибут хүснэгт үүсгэнэ.

*Хүснэгт 1. Бэлчээрийн фото мониторингийн цэг тус бүрийн төлөөлөх талбайн мэдээллийн сангийн талбар (Field) байгуулах загвар*

| №  | Давхаргын нэр                                                                                          | Тоон мэдээллийн нэр |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| 1  | Дэс дугаар                                                                                             | ID                  |
| 2  | Аймгийн код                                                                                            | Aimag_Code          |
| 3  | Аймгийн нэр                                                                                            | Aimag_name          |
| 4  | Сумын код                                                                                              | Soum_Code           |
| 5  | Сумын нэр                                                                                              | Soum_name           |
| 6  | Багийн код                                                                                             | Bag_Code            |
| 7  | Багийн нэр                                                                                             | Bag name            |
| 8  | Бэлчээр ашиглагчдын хэсэг/бүлгийн нэр                                                                  | BAH_Name            |
| 9  | Улирлын бэлчээрийн нэр                                                                                 | Uliral_Belcheer     |
| 10 | Фото мониторингийн цэгийн дугаар                                                                       | Tseg_id             |
| 11 | Фото мониторингийн цэгийн газрын нэр                                                                   | Gazar_Name          |
| 12 | Өргөрөг                                                                                                | Lat                 |
| 13 | Уртраг                                                                                                 | Long                |
| 14 | Байгалийн бүс, бүслүүр                                                                                 | Baigali_bus         |
| 15 | Ургамлын бүрхэц                                                                                        | Cover_urga          |
| 16 | Бодит ургац кг/га                                                                                      | Urgats              |
| 17 | Талбайн хэмжээ, га                                                                                     | Area_ha             |
| 18 | Бэлчээрийн даац                                                                                        | Daats               |
| 19 | Бэлчээрийн экологийн чадавхын бүлгийн код <sup>1</sup>                                                 | ESG_code            |
| 20 | Бэлчээрийн экологийн чадавхын бүлгийн нэр: Газрын гадаргын хэлбэр, хөрс, бэлчээрийг заана <sup>2</sup> | ESG_name            |
| 21 | Төлөв байдлын код <sup>3</sup>                                                                         | Tuluv_cod           |
| 22 | Төлөв байдал <sup>4</sup>                                                                              | Tuluv_baidal        |
| 23 | Бүлгэмдлийн код <sup>5</sup>                                                                           | Bulgem_cod          |
| 24 | Бүлгэмдлийн нэр <sup>6</sup>                                                                           | Bulgem_name         |
| 25 | Сэргэх чадварын ангилал <sup>7</sup>                                                                   | RC                  |

*Тайлбар: Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загваруудаас хүснэгтийн<sup>1, 2, 3, 4, 5, 6, 7</sup> утгуудыг оруулан ашиглах.*





Зураг 7. Монгол орны зонхилох бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварыг ашиглах зөвлөмж




Зураг 8. Хөнгөн шавранцар хөрстэй уулын хажуу, цав толгодын үетэн-крыловын хялганат хуурай хээрийн бэлчээр



### 3.1.3 Газрын мониторингийн системд бэлчээрийн фото мониторингийн цэгийн төлөөлөл талбайг оруулах


Төлөөлөл талбайг нарийвчлан зурагласан тоон зургийг Газрын мониторингийн цахим системд оруулна.

**Газрын мониторингийн системд нэвтрэх:** Интернэт хөтөч (browser) дээрээ <http://192.168.15.216/login> IP хаягийг бичиж орох бөгөөд Газрын мониторингийн цахим систем товч дээр дарна.



Зураг 9. Газрын мониторингийн цахим систем


Мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон газрын даамлууд өөрсдийн нэвтрэх нэр болон нууц үгийг ашиглан системд нэвтрэнэ.



Зураг 10. Газрын мониторингийн цахим системд нэвтрэх буй байдал




**Фото мониторингийн цэгийн талбай оруулах:** Газрын мониторингийн системийн “Бэлчээр” цэсийн “Мониторингийн цэг” хэсгийг сонгоно. Энэ хэсгээс “Цэгийн талбай” товч дээр дарахад дараах цонх нээгдэнэ.



Зураг 11. Төлөөлөх талбайг оруулж байгаа байдал


Дээрх цонхноос “Шинээр нэмэх” товчийг дарахад дараах цонх нээгдэх бөгөөд “Choose files” товчийг дарна.

Газар зүйн мэдээллийн системийн программ хангамж (ArcGIS, QGIS) ашиглан төлөөлөх талбайн хэмжээг мониторингийн цэг тус бүрээр зурагласан байх шаардлагатай бөгөөд өөрийн компьютерт хавтас (фолдер) үүсгэн, .shp өргөтгөлтэйгөөр хадгална.



Зураг 12. Төлөөлөх талбайн \*.shp файлыг оруулж байгаа нь


Дараа нь “Choose files” товч дээр дарж өөрийн компьютерт хадгалсан хавтаст “**Фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайн \*.shp**” файлыг сонгоно. Жишээ: Baganiur\_soum\_point.shp



Зураг 13. Төлөөлөх талбайн .shp файлууд

Газрын мониторингийн цахим системд оруулах фото мониторингийн цэгийн төлөөлөх талбайн .shp файлыг сонгосны дараа “shp файл ачаалах” товчийг дарахад оруулах мэдээллүүд жагсаалт байдлаар харагдах бөгөөд “Геометр” баганад мэдээлэл алдаатай байгаа эсэхийг харуулна.


“Ачаалсан мэдээллийг арилгах” товчийг ашигласнаар бүх мэдээллийг цэвэрлэн дахин засварлаж оруулах боломжтой.



Зураг 14. Төлөөлөх талбайн мэдээллийг алдаагүй оруулж байгаа нь


“Алдаатай хэсгийг үлдээгээд оруулах” товчийг дарахад дээрх цонх нээгдэх бөгөөд дараах байдлаар сонголт хийснээр төлөөлөх талбайг мэдээллийн санд оруулна.






Зураг 15. Газрын мониторингийн цахим системд талбайн мэдээллийг оруулж байгаа нь


Газрын мониторингийн системд мониторингийн цэг бүрээр зурагласан төлөөлөх талбайн хэмжээг доорх зурагт үзүүлэв.



Зураг 16. Ховд аймгийн Алтай сумын Алтангадас нэртэй мониторингийн цэгийн талбай



Зураг 17. Налайх дүүрэг, Ухаа худаг цэг



Багануур дүүрэг, Тариан булаг цэг

### **Дөрөв. Зураглалын үр дүнгээр хэвлэлийн эх бэлтгэх**

Төлөөлөх талбайн зураглалыг хэвлэлийн эх бэлтгэн тохирох масштабаар хэвлэж, хэрэглээнд гаргаж болно.

Ялангуяа бэлчээрийн газрыг хамгаалах, сэлгэж өнжөөх сайжруулахад, улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн даацын дараах сэдэвчилсэн зураг гаргахад ашиглана. Үүнд:

- Хэвлэлийн хуудасны А0 хэмжээгээр бэлтгэхэд тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 500000 га-аас бага бол 1:100000-ны масштабаар, талбайн хэмжээ 500000 га-аас их бол 1:150000-ны болон түүнээс жижиг масштабаар бэлтгэнэ.
- Хэвлэлийн хуудасны А3 хэмжээгээр бэлтгэхэд тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 500000 га-аас бага бол 1:450000 масштаб болон түүнээс том масштабаар бэлтгэнэ. Хэрэв талбайн хэмжээ 500000 га-аас их бол 1:850000 масштаб болон түүнээс жижиг масштабаар бэлтгэнэ.
- Хэвлэлийн хуудасны А4 хэмжээгээр бэлтгэхэд тухайн сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 500000 га-аас бага бол 1:500000 масштаб болон түүнээс том масштабаар бэлтгэнэ. Хэрэв сумын нутаг дэвсгэрийн хэмжээ 500000 га-аас их бол 1:600000 масштаб болон түүнээс жижиг масштабаар бэлтгэнэ.

---oo00oo---